



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 1/405

Хэрлэн сум

Хамтран ажиллах гэрээний хүрээнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.15, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгөөс зориулалт зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Ард иргэдийн эрүүл мэндийг дээшлүүлэх, эрүүл мэндийн салбарын эмч, ажилтнуудыг чадавхжуулах зорилгоор Бүгд Найрамдах Солонгос Улсын "Jeonie design hospital" эмнэлэгтэй байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд тус эмнэлгийн хамт олон орон нутагт ирж ажиллахад зориулж 2,638,400 (хоёр сая зургаан зуун гучин найман мянга дөрвөн зуу) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд зарцуулах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны
07 дугаар сарын 25-ны өдрийн
.../1105 дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэгж дүн	Нийт дүн
1	Байр	12	203,200	2,438,400
2	Талархал	1	200,000	200,000
3	Нийт			2,638,400